

Living the

LOTUS

Buddhism in Everyday Life

10
2017

VOL. 145

ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧИЙН СУРГААЛ

Боловсролтой хүн

Сүүлийн үед соёлын өдөрлөг ихээхэн зохиогдох болжээ. Соёл гэдэг үгийг англи хэлнээс орчуулбал боловсрол, хүмүүжил гэсэн утгатай ба “хөрс шороо боловсруулах” гэсэн үгнээс гаралтай аж. Тэгэхээр сэтгэлээ боловсруулсан хүнийг боловсролтой хүн гэж хэлэх юм болов уу?

Сайн боловсорсон хөрс ямар ч ургамалыг өсгөн ургуулдаг шиг, мэдлэг боловсрол сайтай хүн хэт туйлширч, тогтсон үзэл баримтлалд авталгүй аливаа зүйлийг олон өнцгөөс харж чаддаг. Гэхдээ өөрийгөө цэгнэж байхгүй бол эсрэгээр мэдлэг чадвараараа бардамнаж, хүний үгийг сонсохгүй, бусдыг дорд үзэх хандлагатай

болох хүн ч бий.

Цагаан лянхуа сударт “зөөлөн номхон буян хураагчид” гэсэн хэсэг байдаг. Энэ нь даруу төлөв, жинхэнэ боловсролтой хүн болохын тулд мэдлэг чадвараа дээшлүүлэхийн хажуугаар хүмүүсийн тусын төлөө үйл хийх буюу буян хураах чухал гэсэн үг юм.

Хүмүүсийн сайн сайхны төлөө үйл хийхгүйгээр, өөрийгөө л мундаг харагдуулахын төлөө сурч мэдэх юм бол юун боловсролтой хүн болох, эсрэгээр мэдлэгээр гоёсон өөрийгөө магтсан хүн болж орхино. “Өөрчлөгдөх нь сурч боловсорсныг илтгэнэ” гэсэн үг байдаг шүү дээ.

Living the Lotus Vol. 145 (2017.10)

Хэвлэсэн: Рисшо Косей Кай, Олон улсын хэлтэс

Хаяг: Fumon Media Center, 2-7-1 Wada, Suginami-ku, Tokyo 166-8537 Japan

TEL: +81-3-5341-1124

FAX: +81-3-5341-1224

Email: living.the.lotus.rk-international@kosei-kai.or.jp

Ахлах редактор: Мизүтани Шёокоо

Орчуулсан: Ж.Гэрэлтуяа, Б.Мөнхцэцэг

Эхийг хянасан: Монголын РКК

Рисшо Косей кай байгууллага нь Үүсгэн байгуулагч Нивано Никкёо болон түүний шавь Хамтран үндэслэгч Наганума Мёокоо нарын санаачлагаар 1938 онд байгуулагдсан ба “Гурван Эрдэнийн Цагаан Лянхуа Судар”-ыг гол сургаал номлолоо болгодог, лам бус эгэл хүмүүс нэгдсэн буддын шашны байгууллага юм. Өөрөөр хэлбэл Шагжамүни бурхан багшийн сургаалыг гэр бүл, ажил, нийгмийн амьдралдаа хэрэгжүүлж, дэлхийн энх тайвныг бүтээн байгуулья гэсэн хүсэл зорилготой хүмүүсийн нэгдэл юм. Гишүүд бид бурхан багшийн шавь болохынхоо хувьд тус байгууллагын Ерөнхийлөгч Нивано Ничикоогийн удирдлага дор бурханы сургаалыг түгээх үйлсэд зүтгэж, шашны төдийгүй бусад салбарын байгууллагууд, дэлхийн олон орны хүмүүстэй сэтгэл нэгдэн, энх тайвны олон янзын үйл ажиллагаа явуулж байна.

Living the Lotus – Buddhism in Everyday Life (Амьд Цагаан Лянхуа судар – Буддизм бидний амьдралд)” хэмээх тус сэтгүүлийн нэрэнд, Цагаан лянхуа судрын сургаалыг өдөр тутмынхаа амьдралд хэрэгжүүлж, шаварт ургадаг үзэсгэлэнт лянхуа цэцэг мэт үр бүтээмжтэй, үнэ цэнэтэй амьдралыг туулцаага гэсэн хүсэл шингэсэн билээ. Бид энэхүү сэтгүүлээр дамжуулан өдөр тутмын амьдралдаа хэрэгжүүлж болох бурханы сургаалыг дэлхийн өнцөг булан бүрт хүргэж байна.



ЕРӨНХИЙЛӨГЧИЙН СУРГААЛ

“Зовлон шаналал” ба “зовлон бэрхшээл”

Рисшо Косей Кай, Ерөнхийлөгч
Нивано Ничикоо

Зовж шаналах нь “чухал зүйл”

Ямар ч хүн аль болох зовж шаналахгүй юмсан гэж боддог. Гэвч хичнээн аз жаргалтай харагддаг хүнд ч гэсэн их, бага хэмжээгээр зовж шаналах зүйл байдаг болов уу.


Зовлон бэрхшээл их туулсан туршлага нь дараа нь тэр хүний сэтгэлийг баяжуулсан гэх яриа их сонсогддог. Энэ сарын дөрвөнд амин өдөр нь тохиох Үүсгэн байгуулагч хүүхдийнхээ өвчнөөр дамжуулж шашин шүтлэгтэй учирч, дараа нь амьдралд нь томоохон өөрчлөлтийг авчирсан Цагаан лянхуа судартай учирсан байдаг. Эндээс үзэхэд “зовлон бэрхшээл байж байж л хүн сургаал сурахыг эрмэлзэж, хэрхэн амьдарвал зохилтой юм бол хэмээн нухацтай боддог” гэж хэлж болно. Буруу ойлголт төрүүлж магадгүй ч, хүн зовж шаналах тусмаа хөгждөг ба зовлон бэрхшээл нь чухал туршлага болдог гэж би боддог юм.

Гэсэн хэдий ч аль болох зовохгүй юмсан гэж боддог нь хүний байгалийн зан. “Зовж шаналах зүйлтэй байх сайхан” гэж бол бүр ч бодож чадахгүй.

Мэдээж хэрэг заавал тэгэж бодох шаардлагагүй, байгаагаараа байхад болно. “Усны хүйтэн, халууныг амталж байж мэднэ” гэсэн Зэн буддизмын сургаал байдаг. Үүнтэй адил зовлон бэрхшээл нь нандин туршлага болох “чухал зүйл” гэдгийг янз бүрийн туршлага хуримтлуулж байж л ойлгох ба “үнэхээр чухал зүйл байсан байна”, “зовсны ачаар л жаргаж байна” хэмээн хүлээж авдаг болно гэж бодож байна.

“Бэрхийг туулсан их хүмүүн” болцгооё

Шагжамүни будда “хамаг бүхэн зовлон” хэмээн энэ ертөнц тэр чигээрээ зовлон болохыг сургасан. Харин Үүсгэн байгуулагч “Хамаг бүхэн зовлон гэсэн энэхүү ертөнцийн жинхэнэ үнэний хуулийг сайтар ухаарч, сэтгэлийнхээ гүнд дахин бат бөх суулгах нь юунаас ч илүү чухал. Ингэснээр зовлон гэдэг зүйл огтхон ч сонин зүйл биш бөгөөд хүний





амьдралд тохиолдох энгийн л нэг зүйл болохыг ойлгоно. Зовлонг энгийн амьдралаас тусдаа өөр зүйл гэж боддог болохоор л хэцүү санагдаж, өмнө нь төсөөлөн бодож сэтгэлээ зовоодог юм” хэмээн айлдсан.

Гэвч бид яагаад ч нэмэргүй гэдгийг нь мэдсээр байж ямар нэгэн аргаар зовлонгоос мултрах юмсан хэмээн шаналж, өдрийг бухимдан өнгөрөөх нь цөөнгүй.

Буддын Тэндаи урсгалын их багштан Сакаи Юүсаи тийм үед “ях вэ гэж толгойгоо гашилгаж байхаар биеэрээ ямар нэг зүйл хийхэд анхаарлаа төвлөрүүлсэн нь дээр” гэж хэлдэг.

Зовлон гэдэг үгийг ханз үсгээр хоёр янзаар бичдэг. Эхний ханз нь “сэтгэл үймэрч, бодож шаналан зовох” гэсэн утгатай байдгаас үзвэл асуудал, бэрхшээл толгойд “овоорч”, хий дэмий эргэлдэх гэсэн утгатай мэт санагдаж байна.

Харин нөгөө ханз нь “ямар нэг хэцүү зүйл хийж хөлсөө урсган зовох” гэсэн утгатай байдгаас үзвэл асуудлыг шийдэхийн тулд ямар нэг зүйлийг хийж урагш ахих гэсэн утга агуулагдаж байна. Өөрөөр хэлбэл энэ нь дээр өгүүлсэн нандин туршлага хуримтлуулж байна гэсэн үг болох болов уу.

Дээр үеэс “бэрхийг туулсан хүн” гэхээр олон янзын бэрхшээлтэй тулгарч, тэр нь мэдлэг туршлага болж, амьдралын наад цаадахыг ойлгодог, сэтгэл уужуу, аливаа зүйлийг олон талаас нь хардаг хүнийг хэлдэг байсан.

Ийм хүн болох гэдэг утгаар нь аваад үзэх юм бол зовлон бэрхшээлтэй тулгарсан үедээ биеэрээ “ямар нэг зүйлийг хийж үзэх нь дээр” юм. Ингэснээр “зовлон шаналал” нь “зовлон бэрхшээл” болж хувирна. Улмаар бодож сэтгэх, харах өнцөг тэлж, сэтгэл уян хатан, нинжин болж, хүний хувьд олон талаараа хөгжих нь дамжиггүй.

Манай байгууллагад “зовж шаналсан үедээ адилхан зүйл дээр зовж шаналж байгаа хүний сэтгэлийг сонсох чухал” гэж сургадаг нь ч гэсэн бэрхшээлээс зугталгүй бусдын төлөө үйл хийснээр “зовлон шаналал” нь “зовлон бэрхшээл” болж хувирах гол түлхүүр болохоор юм. Талархсан сэтгэл ч гэсэн эндээс л бий болдог.

“Бэрхийг туулсан их хүмүүн” гэвэл олон түмнийг аз жаргалтай болгохыг зорин сургаал номоо айлдан түгээсэн Шагжамүни будда билээ.

“Косей” сэтгүүл 10-р сарын дугаараас



Яг энэ мөчид талархах

Күмамото салбар
Катоо Эцүко

Энэхүү илтгэл нь 2017 оны 4 сарын 1-нд Их ариун ордонд тавигдсан болно.

Та бүхэнд энэ өдрийн амар амгаланг айлтгая. Өнгөрсөн жилийн Күмамотогийн газар хөдлөлтөөр чин сэтгэлийн тусламж үзүүлсэн Нивано ерөнхийлөгч болон санга та нартаа талархал илэрхийлье.

Би 1972 онд Күмамото мужийн Машики хотод Нишиямагийн охин болж мэндэлсэн. 3 насаар ах ах бид хоёрыг аав ээж, өвөө эмээ маань юугаар ч дутаалгүй хайрлаж өсгөсөн. Ээж намайг хэвлийдээ тээж байх үед аав эмэгтэй хүнтэй орооцолдож, ээж намайг төрүүлээд эмнэлэгт хэвтэж байхдаа өдөр бүр уйлж, төрсөн гэр лүүгээ харих талаар л боддог байсан гэсэн. Намайг 5 сартай байхад аавын авга эгч ээжийг Рисшо Косей Кай (РКК) байгууллагад элсүүлсэн. Хүүхэд байхад ээж ажлаасаа ирээд гэрийн ажлаа хийчихээд гэрийн ойролцоох айлаар явж нийгэмлэгийн сонин сэтгүүл тараадаг байсан. Би дагаж яваад айлд унтчихаад, ээждээ үүрүүлэн харьж ирдэг байв. Сургуульд ороод ах бид хоёр Күмамото нийгэмлэгийн бүтэнсайны сургууль болон сургалтанд оролцог байсан.

Би нөхөртэйгөө гэрлэснийхээ дараа л анх удаа сүсэг бишрэлийн талаар боддог болсон. Их сургуулийн 3-р курсэд байхдаа цагийн ажил хийдэг байсан газрын эзэн 17 насаар ах хүнтэй танилцаж үерхэж эхэлсэн. Тухайн үед түүний анхны эхнэр нь өвчнөөр өөд болж, 5-р ангид сурдаг хүүтэйгээ амьдардаг байсан. Эхнэр нь өөд болохын өмнөхөн мэндэлсэн тухайн үед 3 настай байсан охиныг нь хадам аав ээж хоёр нь өөр дээрээ авсан тул хамт амьдардаггүй байсан. Би хүүхдээ өсгөх гэж хичээж байгаа эелдэг, түшигтэй тэр хүнтэй гэрлэх талаар бодох болов. 2 хүүхдийн ээж болж чадах байгаа гэж санаа зовон аав ээжтэйгээ зөвөлтөл огт эсэргүүцэлгүй “чи бол чадна аа, тусалж дэмжих болно оо” гээд надад итгэсэн. Гэвч үнэндээ энэ үг нь охиныгоо ирээдүйд сайн сайхан амьдраасай хэмээн хүсэж өсгөсөн аав ээж минь эсэргүүцмээр байсан

сэтгэлээ дарж, арай ядан амнаасаа унагасан үг байсныг би одоо өөрөө эх хүн болж байж л ойлгож байна. Аав ээжийн хэлсэн энэ үг ямар ч үед намайг зоригжуулдаг байсан. Үргэлж надад гүн гүнзгий нийгүүлсэнгүй сэтгэлээр зааж зөвлөдөг аав ээждээ баярлалаа.

Би 1996 онд их сургуулиа төгсөөд нөхөртэйгөө гэрлэж, 7-р ангийн хүү, 5 настай охинтой нь хамтдаа амьдрах болов. Гэрлэхээс өмнө хүүтэй нь цагийг их өнгөрүүлдэг байсан болохоор хүү их баярласан. Төрөлхийн өвчтэй байсан өмнөх эхнэр нь охиноо төрүүлэхийнхээ өмнөхөн тархины цус алдалтаар ухаан алдаж, охиноо хагалгаагаар төрүүлсэн гэсэн. Түүнээс 2 долоо хоногийн дараа эхнэр нь нас барж, охин нь эхийнхээ энгэрт ганц ч удаа тэврүүлж үзээгүй байсан юм. Тэгээд хадмууд нь хайрлан өсгөж, эмзэг мэдрэмтгий хүүхэд болж өссөн байв. Аав нь надтай гэрлэснээр “би ээжтэй боллоо” гээд аав дээрээ ирсэн. Хүнд хурдан дасдаг охин маань надад ч гэсэн амархан дассан боловч эцэг эхийг нь орлож байсан өвөө эмээгээсээ салахад балчир охины хувьд хэцүү байсан байх. Тийм болохоор шөнө үе үе уйлдаг байсан. “Одоо зүгээр ээ” гээд аргадсан ч гэсэн уйлахаа болихгүй болохоор нь



Их ариун ордонд илтгэл тавьж байгаа нь

өвөө эмээ дээрээ байх нь сайхан байвал буцааж явуулсан нь дээр юм болов уу гэж бодон уйлах үе ч байсан. Дараа нь нөхөр бид хоёрын хооронд хүү, охин хоёр төрсөн юм. Том охин маань 2 дүүтэй болоод өөрөө эрхэлж чадахгүй болохоороо дүүдээ уураа гаргах болов. Энэ талаар би дүүргийн ахлагч болон ээж нарын бүлгийн ахлагтайгаа зөвлөснөөр гэр бүлийн сургалт гэх мэт янз бүрийн сургалтанд суух болсон. Гэхдээ нөхөр шашин шүтлэгт дургүй байсан болохоор эхэндээ нөхөртөө хэлдэггүй байсан. Ээж нарын бүлгийн Ариун ордны мөргөл, Оомэ дахь сургалт гэх мэт үйл ажиллагаа болох үед нөхөртөө дуртай хоолыг нь хийж өгөн, гэртээ нийгэмлэгийн 3 үндсэн үйлийг хэрэгжүүлэнгээ нөхөртөө нийгэмлэгийн талаар бага багаар хэлж, ойлгуулдаг болсон.

Том охин маань насанд хүрэх үед охиныхоо үг хэл, үйл хөдлөлд нь санаа зовох болсон. Тэр үеэс дүүргийн хүүхдийн бүлгийн ахлагч, дараа нь дүүргийн ээж нарын бүлгийн ахлагч үүргийг авч, ээж нарын бүлгийн 1, 2, 3-р түвшиний сургалтанд сууж ээж нартай баяр хөөр, зовлон гунигаа хуваалцах болсон. Улмаар санаанд нийцэхгүй зүйлээр дамжуулж Бурхан надад юуг зааж сургаж байгаа юм бол гэж боддог болсон. Том охинтойгоо яаж харилцахаа мэдэхгүй байх үедээ хэсгийн ахлагч болон багийн ахлагчаас зөвлөгөө авч, сэтгэлээ засаж байсан. Тэгээд яг одоо нөхөр, хүүхдээ асран халамжилж байгаа нь ямар сайхан зүйл болохыг ойлгож, гэр бүлийнхнийхээ төлөө чадлаараа хичээс гэж бодох болсон. Түүнчлэн охиных нь оронд ирсэн зээ охиноо надад даатган өгч, 2 зээгийнхээ аз жаргалын төлөө залбирч ирсэн нөхрийн өмнөх эхнэрийн аав ээж хоёрын итгэлийг алдахгүй юмсан, нөхрийнхөө хүүхдүүдтэй жинхэнэ эх үр болох юмсан гэж боддог байсан.

2012 оны 3 сард ганц ч удаа өвдөж үзээгүй эрүүл саруул байсан би усанд орж байхдаа гэнэт их хэмжээний цус алдсан юм. Эмэгтэйчүүдийн эмнэлэгт үзүүлтэл хэвлийн хорт хавдар гэж оношлогдон, бусад газруудад тархах аюултай тул аль болох хурдан мэс засал хийх шаардлагатай гэв. Толгойд үхэх тухай л бодогдож, юу ч бодох сөхөөгүй болсон. Хэрвээ би үхчих юм бол гэр бүл минь яах билээ гэж бодогдох үед 2 хүүхдээ орхиод бурханы оронд

одсон нөхрийн өмнөх эхнэр бодогдож, эхнэр хүн, ээж хүний хувьд нөхөр, хүүхэддээ олон зүйл хийж өгмөөр байсан ч хийж өгч чадаагүй харуусал гунигын талаар бодохгүй байж чадахгүй байсан. Мэс заслын өдөр товлогдох хүртэл өдөр бүр санаа зовч, цээж дэлсэж байлаа. Хэсгийн ахлагчдаа сэтгэлээ уудалж ярилцсанаар өвчин болон цаашдын амьдралыг өөрийн хүчээр шийдэж чадахгүй болохоор Бурханд итгэж, бүгдийг даатгая гэж шийдсэн. Гэтэл гайхалтай нь сэтгэл уужираад ирсэн. Тэгээд ажлаасаа гарч, буян хураангаа мэс засал хүртэлх өдрүүдийг гэр бүлдээ зориулж, сэтгэл тайван байж чадсан. Болдог бол өөрийгөө чиний оронд тавьчих юмсан гэж намайг хайрлаж, миний төлөө залбирч байсан аав ээж, санаа зовж байсан нөхөр, хүүхдүүдээ тайвшруулахын тулд миний хийж чадах зүйл бол өдөр бүрийг өөдрөг, гэгээлэг өнгөрөөх явдал байсан юм. Азаар олон зүйлийн ачаар мэс засал амжилттай болж, өвчин дахин сэдэрч, өөр газар руу тархах зүйлгүй өнөөдрийг хүртэл сайхан амьдарч байна. Эмнэлгээс гараад нийгэмлэгийнхээ бурханыг харах тэр мөчид Бурхан, өвөг дээдэс, маш олон хүмүүсийн ач буянаар өнөөдөр амьд яваадаа талархах сэтгэл төрж, сэтгэл догдолж, нулимс асгарав. Би өвчнөөр дамжуулж аз жаргалаар дүүрэн байгаагаа олж анзаарсан. Мөн өвчин туссан нь өвдөж шаналсан хүмүүсийн сэтгэлийг ойлгодог болгохын төлөөх Бурханы нигүүлсэхүй байсныг ойлгож, амь насаа бусдын сайн сайхны төлөө зориулах нь миний үүрэг юм байна гэж бодогдсон.

2016 оны 6 сард том охин маань 2 дахь хүүхдээ төрүүлсэн юм. Гэвч хүргэний ажил ургашгүй байсан тул охин 2 хүүхэд өсгөнгөө ажил хийх шаардлагатай болж, сэтгэл санааны хувьд тогтворгүй байв. Тэр үед би нийгэмлэгийн сургалтын албаны үүрэг гүйцэтгэнгээ зээ нараа хардаг байв. Нэг өдөр охин хуралдсан байсан уур бухимдлаа надад гаргасан юм. Охин намайг элдвээр хэлж, бүр барьцалдан авч бөөн хэрүүл болов. Зээгээ тэвэрсэн байхыг минь хүртэл үл тоон дайрч давшилах охиныг нөхөр хүртэл зогсоож дийлээгүй ба хөршүүд цагдаа руу утасдаж цагдаа ирж байж нэг юм хэрүүл намжсан.

“Ээжийгээ гэж нэг ч удаа бодож үзээгүй.” “Цусан төрлийн холбоогүй юм байж ээж болох гэж хичээх хэрэггүй.” Охины ингэж хэлэхийг сонсоод би цочирдсон юм. “Охин минь ингэж бодож байсан гээд бодохоор миний 20 жил хичээсэн хичээл зүтгэл хоосон зүйл байсан гэж үү. Жинхэнэ ээж нь болох эцсийн эцэст талаар өнгөрлөө гэж үү” гэж бодон өөртөө итгэх итгэлгүй болж, биенээс илүү сэтгэл маш ихээр өвдсөн. Охиныхоо талаар бодохоор нулимс асрагаад, нойр хүрэхгүй өдөр олон байсан. Тэгээд биеэ сайжиртал нийгэмлэгээс амралт авав. Тэр үед аав ээж, хэсгийн ахлагч, сураглтын албаны ахлагч нар санаа зовон эргэж ирж байсан. Ингээд л байгаад байвал юу ч өөрчлөгдөхгүй гэж бодон нийгэмлэгийн тэргүүнээс сургаал сонсохоор очив. Тэргүүн “хичээл зүтгэл чинь дутуу байсан юм биш, харин ч хичээж зүтгэж ирсэн болохоор л чамайг даваад гарч чадна гэдэгт итгэж Бурхан ийм зүйлтэй учруулсан гэж бодож байна” гэж хэлэн, сэтгэлийн гүн шарх авсан надад санаа тавьсан. Сэтгэлээ засрах хүртлээ хичнээн санаа зовж байсан ч гэсэн охиноо нөхөрт нь даатгах хэрэгтэй гэсэн тэргүүний үгийг сонсоод охиныхоо өмнө өөрийгөө буруутгаж байсан миний сэтгэл жоохон уужирсан юм. Гэсэн хэдий ч би охиныхтой адилхан машин харах төдийд л зүрх салганадаг байсан. Тэр явдлаас хойш бүтэн жил охин, зээ нартайгаа уулзаагүй. Тэр хугацаанд 12-р ангийн хүү, 10-р ангийн охин хоёр маань хоорондоо ярилцаж байгаад эгч дээрээ очин, хоорондоо холбоотой байсан. Тэгээд надад эгчийнхээ талаар мэдээлэл хурагддаг байсан.

Нэг өдөр бага охинтойгоо том охиныхоо талаар ярьж байтал “эгч тийм хэцүү зүйлийг даван туулж төрөөгүй байсан бол би ч гэсэн төрөөгүй байх байсан байх” гэж хэлсэн юм. Энэ үг надад их ухаарлыг өгсөн. Том охин төрсөн эхээсээ хагацан байж энэ ертөнцөд мэндэлж, ээж нь ч гэсэн амь насаараа охиноо солин байж төрүүлсэн болохоор л би нөхөртэйгөө учирч, 2 хүүхэд төрүүлж, одоо ийнхүү сайхан амьдарч байгаа. Том охин маань аз жаргалтай байх юм бол би ч гэсэн аз жаргалтай байна гэдгийг би 20 жилийн дараа анх удаа ойлгосон юм. Одоо том охин 3 хүүхдээ өсгөхийн төлөө хичээж байгаа.

Манайд ч гэсэн ирдэг болсон. Нөхөр бид хоёрын хувьд хэцүү үед нэг нэгэндээ туслах 4 хүүхдийнхээ өсөж том болсныг харах хамгийн том аз жаргал байдаг.

Өнгөрсөн жилийн 11 сард тэргүүн нийгэмлэгийн ээж нарын бүлгийн ахлагч болох хүсэлт тавьсан юм. Гэр бүлийн эдийн засаг хэцүү байгаа үед ажлаа болиод үүргээ биелүүлж чадах болов уу гэж бодохоор сэтгэл зовоод нойр ч хүрэхгүй байв. Тэр үед би болоогүй зүйлийн талаар бодож өөрийгөө зовоон, тухайн цаг мөчид байгаа сайхан зүйлд баярлаж чаддаггүй болохоо олж анзаарсан юм. Мөн ирээдүйн төлөө санаа зовоод байх юм бол одоодоо анхаарч чадахгүй гэдгийг ойлгосон. Тэгээд үүргээ биелүүлж чадахгүй хэцүү үедээ заавар зөвлөгөө авангаа тэр үед нь л бодоход болох юм байна гэж бодон үүргийг хүлээж авахаар шийдсэн.


Ийнхүү Күмамото нийгэмлэгийн 60 жилийн ойн баяр тохиосон энэ билигт сайхан жил дараагийн үеийг хүмүүжүүлэх ээж нарын бүлгийн ахлагчийн үүрэг авсан маань Бурханы ач ивээл гэж бодож байна. Цаашид бүлгийн гишүүдтэйгээ харилцах харилцаагаар дамжуулж талархсан сэтгэлээ илүү ихээр илэрхийлж, яг одоодоо төвлөрч, бурханы үйлийг хэрэгжүүлэхээ тангараглаж байна.

Анхаарал тарин сонссон та бүхэнд баярлалаа.



Ээж нарын бүлгийн гишүүдтэй цаасаар цэцэг хийж байгаа нь

Living the **LOTUS**



Хүүд маань гэрлэх хүн олдохгүй байна, яах вэ?

Q

Хүү маань 40 гарсан боловч гэрлээгүй байгаад санаа зовоод байна. Манайх хөдөө тосгонд амьдардаг ба ихэнх залуучууд хот газар ажиллахаар явчихдаг болохоор хүнтэй танилцах боломж бараг байдаггүй. Хүү болохоор “танд хань болоод энэ гэрт амьдрах хүн зүгээр байна” гэж хэлдэг. Сүүлийн үед зуучлалаар танилцах хүсэлт ч бараг ирэхгүй байгаа болохоор хүүгийнхээ ирээдүйн төлөө санаа зовоод байх юм.



A

Хүүгээ хурдан аз жаргалтай болоосой гэсэн таны сэтгэлийг сайн ойлгож байна. Мөн ээждээ санаа тавьж байгаа хүүгийн тань сэтгэлийг ч ойлгож байна. Бие биенийхээ төлөө бодоод санаа зовоод байгаа юм болов уу гэж бодогдож байна. Тийм болохоор хоорондоо чин сэтгэлээ уудлан ярилцаад үзвэл ямар вэ?

Бие биенийхээ бодож байгаа зүйлийг ойлгох чухал. Тэгээд та “ээждээ санаа зоволтгүй ээ, чи өөрийнхөө хүссэн замаараа л яв” хэмээн хүүдээ итгэн, үнэн сэтгэлээсээ дэмжиж өгөхийг хүсэж байна. Итгэлцэл бий болсноор хүү тань насанд хүрсэн болохоо ухамсарлаж, урагш алхах болов уу гэж бодож байна.

Мөн хүү тань эхнэр хайж, ангийн уулзалт гэх мэт уулзалтанд очих зэргээр өөрөөсөө хичээл зүтгэл гаргах хэрэгтэй. Санаснаар болохгүй байж магадгүй ч хүмүүстэй харилцаж, янз бүрийн туршлага хуримтлуулснаар хүү тань өөрөө өсөж хөгжих болно.

Сүүлийн үед газар тариалан эрхэлдэг айлын бэр болохыг хүсдэг эмэгтэйчүүд их болсон.

Мөн гэрлэхээр л аз жаргалтай болно гэсэн үг биш.

Ямар ч нөхцөл байдалд байсан үр хүүхэд нь амьдрах эрч хүчээр дүүрэн, сэтгэл өөдрөг байх юм бол эцэг эх ч, үр хүүхэд ч аз жаргалтай байна гэж бодож байна.



Токио гэр бүлийн сургалт, судалгааны институт

Токио гэр бүлийн сургалт, судалгааны институт нь “Эцэг эх өөрчлөгдөх юм бол хүүхэд ч гэсэн өөрчлөгдөнө” гэсэн сурган хүмүүжүүлэх арга ухаанд тулгуурлан газар газарт сургалт семинар зохион байгуулж, хүүхэд өсгөн хүмүүжүүлэх талаар зөвөлгөө өгч байна. Үүгээр дамжуулан олон хүмүүс хүүхдээрээ дамжуулан гэр бүл гэж ямар байдгийг суралцаж, аз жаргалтай гэр бүл олноор төрж байна.



Эх үрийн барилдлага

Ээждээ хань болох хүн биш л бол гэрлэхгүй гэж 40 гартлаа хэлж байдаг хүү тань үнэхээр эцэг эхдээ ачлалтай, буурь суурьтай хүү юм. Эрт гэрлэх тусмаа аз жаргалтай болно гэсэн юм байхгүй. Олон оймс элээх тусмаа юмыг харах өнцөг тэлж, гэрлээд аз жаргалтай амьдарч байгаа хүмүүс олон бий.

Байгууллагын ерөнхийлөгч жинхэнэ аз жаргалын талаар ийнхүү айлдсан байдаг.

“Элэг бүтэн, үр хүүхэдтэй, өдөр бүр эрүүл саруул ажлаа хийж, хоолоо амтархан идэж, өчүүхэн ч байсан хамаагүй хүнд тус хүргэж, олон зүйлийн дэмжлэг туслалцааны ачаар одоо ийнхүү амьдарч байна. Энэ мэтчилэн талархмаар зүйл олныг анзаарч, тоолоод үзэх юм бол амьдралд сайхан зүйл, инээд хөөр, аз жаргал нэмэгдэх болно. Яг одоо өөрт байгаа зүйл, нөхцөл байдал хамгийн талархмаар сайхан гэдгийг ухаарснаар жинхэнэ аз жаргал юу болохыг ойлгоно.” «Сэтгэлийн мэлмийгээ нээх » Х.289, 3-9

Тэгэхээр та яг одоо байгаа аз жаргал юу болохыг хүүтэйгээ ярилцангаа хүүгийнхээ цаашид яамаар байгааг сонсох чухал болов уу гэж бодож байна.

РКК, Сургалтын алба



Please give us your comments!



We welcome comments on our e-newsletter Living the Lotus.


E-mail: living.the.lotus.rk-international@kosei-kai.or.jp

Бэрхшээлийг өөдрөг хүлээж авах

Америцад байхад болсон явдал. 7 хоногийн хугацаатай буддын семинарт оролцож байсан хүмүүс дунд хүмүүсийн дургүйг хүргэсэн нэг эрэгтэй байсан юм. Гэнэт нэг өдөр тэр эрэгтэй семинараас залхаад байрнаас гараад явчихав. Оролцогчид бөөн баяр болов. Харин ламтан хойноос нь машинаар явж, буцаагаад дагуулаад ирэв. Хүмүүс дургүйцэж, нэг хүү “яагаад тэр хүнийг дагуулаад ирж байгаа юм бэ?” гэж асуув. Ламтан “тэгэлгүй яахав дээ, би энэ хүний ачаар бурханы үйл хийж байгаа юм чинь” гэж хариулсан юм.

Амьдралын зовлон, бэрхшээл дуусахгүй. Би энэ сарын Нивано ерөнхийлөгчийн сургаалаас зовж шаналах уу, үгүй юү гэдэг өөрөөс л шалтгаалдаг гэдгийг ойлгосон. Мөн бурханы зам мөрөөр алхах гэдэг нь хэцүү нөхцөл байдалд байгаа өөрийнхөө сэтгэлийг байгаагаар нь дүгнэж, зовлон бэрхшээлийн утга учир, үнэ цэнийг олж анзаарах явдал гэдгийг ойлгосон. Үүсгэн байгуулагч бэрхшээлтэй тулгарахаараа “одоо л улам сонирхолтой болж байна даа” хэмээн өөдрөг хүлээж авдаг байсан гэсэн. Би ч гэсэн бэрхшээлийг ийнхүү өөдрөг хүлээн авч байя гэж бодож байна.

РКК, Олон улсын хэлтсийн дарга
Мизүтани Шёокоо



🌸 RISSHO KOSEI-KAI INTERNATIONAL BRANCHES 🌸

Rissho Kosei-kai Overseas Dharma Centers

2017

Rissho Kosei-kai International

3F Fumon Media Center, 2-7-1 Wada, Suginami-ku, Tokyo, Japan
Tel: 81-3-5341-1124 Fax: 81-3-5341-1224

Rissho Kosei-kai International of North America (RKINA)

2707 East First Street Suite #1 Los Angeles
CA 90033 U.S.A.
Tel: 1-323-262-4430 Fax: 1-323-262-4437
e-mail: info@rkina.org http://www.rkina.org

Branch under RKINA

Rissho Kosei-kai of Seattle's Buddhist Learning Center
28621 Pacific Highway South, Federal Way, WA 98003, U.S.A.
Tel: 1-253-945-0024 Fax: 1-253-945-0261
e-mail: rkseattlewashington@gmail.com
http://buddhistlearningcenter.org/

Rissho Kosei-kai of Vancouver

Rissho Kosei-kai Buddhist Center of San Antonio
6083 Babcock Road, San Antonio, TX 78240, U.S.A.
P.O. Box 692148, San Antonio, TX 78269, USA
Tel: 1-210-561-7991 Fax: 1-210-696-7745
e-mail: dharmasanantonio@gmail.com
http://www.rkina.org/sanantonio.html

Rissho Kosei-kai of Tampa Bay
2470 Nursery Road, Clearwater, FL 33764, U.S.A.
Tel: (727) 560-2927
e-mail: rktampabay@yahoo.com
http://www.buddhismtampabay.org/

Rissho Kosei-kai Buddhist Church of Hawaii

2280 Auhuhu Street, Pearl City, HI 96782, U.S.A.
Tel: 1-808-455-3212 Fax: 1-808-455-4633
e-mail: info@rkhawaii.org http://www.rkhawaii.org

Rissho Kosei-kai Maui Dharma Center
1817 Nani Street, Wailuku, HI 96793, U.S.A.
Tel: 1-808-242-6175 Fax: 1-808-244-4625

Rissho Kosei-kai Kona Dharma Center
73-4592 Mamalahoa Highway, Kailua-Kona, HI 96740, U.S.A.
Tel: 1-808-325-0015 Fax: 1-808-333-5537

Rissho Kosei-kai Buddhist Center of Los Angeles

2707 East First Street, Los Angeles, CA 90033, U.S.A.
Tel: 1-323-269-4741 Fax: 1-323-269-4567
e-mail: rk-la@sbcglobal.net http://www.rkina.org/losangeles.html

Rissho Kosei-kai Buddhist Center of Arizona

Rissho Kosei-kai Buddhist Center of Colorado

Rissho Kosei-kai Buddhist Center of San Diego

Rissho Kosei-kai Buddhist Center of Las Vegas

Rissho Kosei-kai Buddhist Center of Dallas

Rissho Kosei-kai of San Francisco

1031 Valencia Way, Pacifica, CA 94044, U.S.A.
Tel: 1-650-359-6951 Fax: 1-650-359-6437
e-mail: info@rksf.org http://www.rksf.org

Rissho Kosei-kai of Sacramento

Rissho Kosei-kai of San Jose

Rissho Kosei-kai of New York

320 East 39th Street, New York, NY 10016, U.S.A.
Tel: 1-212-867-5677 Fax: 1-212-697-6499
e-mail: rkny39@gmail.com http://rk-ny.org/

Rissho Kosei-kai of Chicago

1 West Euclid Ave., Mt. Prospect, IL 60056, U.S.A.
Tel: 1-773-842-5654
e-mail: murakami4838@aol.com
http://home.earthlink.net/~rkchi/

Rissho Kosei-kai of Fort Myers

http://www.rkftmyersbuddhism.org/

Rissho Kosei-kai Dharma Center of Oklahoma

2745 N.W. 40th Street, Oklahoma City, OK 73112, U.S.A.
Tel & Fax: 1-405-943-5030
e-mail: rkokdc@gmail.com http://www.rkok-dharmacenter.org

Rissho Kosei-kai, Dharma Center of Denver

1255 Galapago Street, #809 Denver, CO 80204, U.S.A.
Tel: 1-303-446-0792

Rissho Kosei-kai Dharma Center of Dayton

425 Patterson Road, Dayton, OH 45419, U.S.A.
http://www.rkina-dayton.com/

Rissho Kosei-kai do Brasil

Rua Dr. José Estefno 40, Vila Mariana, São Paulo-SP,
CEP 04116-060, Brasil
Tel: 55-11-5549-4446 / 55-11-5573-8377
Fax: 55-11-5549-4304
e-mail: risho@terra.com.br http://www.rkk.org.br

Rissho Kosei-kai de Mogi das Cruzes

Av. Ipiranga 1575-Ap 1, Mogi das Cruzes-SP,
CEP 08730-000, Brasil
Tel: 55-11-5549-4446/55-11-5573-8377

Rissho Kosei-kai of Taipei

4F, No. 10 Hengyang Road, Zhongzheng District, Taipei City 100, Taiwan
Tel: 886-2-2381-1632 Fax: 886-2-2331-3433
http://kosei-kai.blogspot.com/

Rissho Kosei-kai of Taichung

No. 19, Lane 260, Dongying 15th St., East Dist.,
Taichung City 401, Taiwan
Tel: 886-4-2215-4832/886-4-2215-4937 Fax: 886-4-2215-0647

Rissho Kosei-kai of Tainan

No. 45, Chongming 23rd Street, East District, Tainan City 701, Taiwan
Tel: 886-6-289-1478 Fax: 886-6-289-1488

Rissho Kosei-kai of Pingtung

Korean Rissho Kosei-kai

6-3, 8 gil Hannamdaero Yongsan gu, Seoul, 04420, Republic of Korea
Tel: 82-2-796-5571 Fax: 82-2-796-1696
e-mail: krkk1125@hotmail.com

Korean Rissho Kosei-kai of Busan

3F, 174 Suyoung ro, Nam gu, Busan, 48460, Republic of Korea
Tel: 82-51-643-5571 Fax: 82-51-643-5572

Branches under the Headquarters

Rissho Kosei-kai of Hong Kong

Flat D, 5/F, Kiu Hing Mansion, 14 King's Road,
North Point, Hong Kong, Republic of China

Rissho Kosei-kai of Ulaanbaatar

15F Express tower, Peace avenue, khoroo-1, Chingeltei district,
Ulaanbaatar 15160, Mongolia
Tel: 976-70006960
e-mail: rkkmongolia@yahoo.co.jp

Rissho Kosei-kai of Sakhalin

4 Gruzinski Alley, Yuzhno-Sakhalinsk
693005, Russian Federation
Tel & Fax: 7-4242-77-05-14

Rissho Kosei-kai di Roma

Via Torino, 29-00184 Roma, Italia
Tel & Fax : 39-06-48913949
e-mail: roma@rk-euro.org

Rissho Kosei-kai of the UK

Rissho Kosei-kai of Venezia

Castello-2229 30122-Venezia Ve Italy

Rissho Kosei-kai of Paris

86 AV Jean Jaures 93500 Tentin Paris, France

International Buddhist Congregation (IBC)

3F Fumon Media Center, 2-7-1 Wada, Suginami-ku, Tokyo, Japan
Tel: 81-3-5341-1230 *Fax:* 81-3-5341-1224
e-mail: ibcrk@kosei-kai.or.jp <http://www.ibc-rk.org/>

Rissho Kosei-kai of South Asia Division

3F Fumon Media Center, 2-7-1 Wada, Suginami-ku, Tokyo, Japan
Tel: 81-3-5341-1124 *Fax:* 81-3-5341-1224

Rissho Kosei-kai International of South Asia (RKISA)

201 Soi 15/1, Praram 9 Road, Bangkapi, Huaykhwang
Bangkok 10310, Thailand
Tel: 66-2-716-8141 *Fax:* 66-2-716-8218
e-mail: thairissho@csloxinfo.com

Branches under the South Asia Division

Rissho Kosei-kai of Central Delhi

224 Site No.1, Shankar Road, New Rajinder Nagar, New Delhi,
110060, India

Rissho Kosei-kai of West Delhi

66D, Sector-6, DDA-Flats, Dwarka
New Delhi 110075, India

Rissho Kosei-kai of Kolkata

E-243 B, P. Township, P. O. Panchasayar,
Kolkata 700094, India

Rissho Kosei-kai of Kolkata North

AE/D/12 Arjunpur East, Teghoria, Kolkata 700059,
West Bengal, India

Rissho Kosei-kai of Bodhgaya Dharma Center

Ambedkar Nagar, West Police Line Road
Rumpur, Gaya-823001, Bihar, India

Rissho Kosei-kai of Patna Dharma Center

Rissho Kosei-kai of Kathmandu

Ward No. 3, Jhamsilhel, Sancepa-1, Lalitpur,
Kathmandu, Nepal

Rissho Kosei-kai of Singapore

Rissho Kosei-kai of Phnom Penh

#201E2, St 128, Sangkat Mittapheap, Khan 7 Makara,
Phnom Penh, Cambodia

Thai Rissho Friendship Foundation

201 Soi 15/1, Praram 9 Road, Bangkapi, Huaykhwang
Bangkok 10310, Thailand
Tel: 66-2-716-8141 *Fax:* 66-2-716-8218 *e-mail:* info.thairissho@gmail.com

Rissho Kosei-kai of Bangladesh

85/A Chanmari Road, Lalkhan Bazar, Chittagong, Bangladesh
Tel & Fax: 880-31-626575

Rissho Kosei-kai of Dhaka

House#408/8, Road#7(West), D.O.H.S Baridhara,
Dhaka Cant.-1206, Bangladesh
Tel: 880-2-8413855

Rissho Kosei-kai of Mayani

Mayani(Barua Para), Post Office: Abutorab, Police Station: Mirshari,
District: Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai of Patiya

Patiya, sadar, Patiya, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai of Domdama

Domdama, Mirsarai, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai of Cox's Bazar

Ume Burmese Market, Main Road Teck Para, Cox'sbazar, Bangladesh

Rissho Kosei-kai of Satbaria

Satbaria, Hajirpara, Chandanish, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai of Laksham

Dupchar (West Para), Bhora Jatgat pur, Laksham, Comilla,
Bangladesh

Rissho Kosei-kai of Raozan

West Raozan, Ramjan Ali Hat, Raozan, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai of Chendirpuni

Chendirpuni, Adhunagor, Lohagara, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai of Ramu

Rissho Kosei Dhamma Foundation, Sri Lanka

No. 628-A, Station Road, Hunupitiya, Wattala, Sri Lanka
Tel: 94-11-2982406 *Fax:* 94-11-2982405

Rissho Kosei-kai of Polonnaruwa

Rissho Kosei-kai of Habarana

151, Damulla Road, Habarana, Sri Lanka

Other Groups

Rissho Kosei-kai Friends in Shanghai